





“ХҮНСНИЙ НОГОО” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

2019.12.02

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл		
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилго: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын 02 өдрийн 25 тогтоолын батлагдсан.</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Хөтөлбөрийн зорилго нь хүнсний ногооны тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, хоршоодын үйл ажиллагааг дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэл, хамгаалагдсан хөрсний тариалалт, талбайн хэмжээг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээний 20 хувийг хангадаг болно.</p>		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯамнаас		
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААГазар		
4.	Төсөл, зорилтууд хөтөлбөрийн	<p>Зорилт1:Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах :</p> <p>Зорилт2:Шинэ техник, технологи, усалгаатай талбай, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх:</p> <p>Зорилт3:Технологийн ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үр, бордоо, гербицид, фунгицид, гар багаж, усалгааны, хүлэмжийн тоног төхөөрөмжийг үндсэн үнээр нь нийлүүлэх худалдааны цэг байгуулах :</p> <p>Зорилт4:Тариалан эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах:</p> <p>Зорилт5:Газар тариалангийн бүс нутагт төмс, хүнсний ногоо тариалах талбайг түрээсээр ашиглах нөхцөл боломжийг судалж хэрэгжүүлэх</p>		
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Орон нутгийн төсвөөр-2019 онд	
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл

		Багц 1	2018 онд Сум хөгжүүлэх сангаас 77,6 сая/төгрөгийн дэмжлэгийг 3 жилийн хугацаатайгаар олгон ажиллаж байна.	Энэ оны зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь 100 хувь төлж дуусгалаа.	100
		Багц 2	2019 онд Сум хөгжүүлэх сангаас 109,0 сая/төгрөгийн дэмжлэгийг 3 жилийн хугацаатайгаар олгон ажиллаж байна.	Сайнцагаан, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрцогт сумдын 5 иргэд нийт 109,0 сая /төгрөгний зуны хүлэмж, төмс, хүнсний ногоо тариалах, үр бордооны төхөөрөмж авахаар сарын 0,25%-ийн хүүтэй 3 жилийн хугацаатай зээл авсан.	100
	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Хөтөлбөрийн биелэлтийг доорх талбарт бичнэ.			
6.	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:	<p>1-р Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл.</p> <p>1.1.Өвлийн хүлэмжид 1473 м² талбайд тариалсан, талбайн хэмжээ урьд оноос 273 м² -аар нэмэгдэж. Хураан авсан ургац урьд оноос 3,3 тн-оор нэмэгдэж өссөн байна.</p> <p>Аймгийн хэмжээнд зуны хүлэмжийн тоо 71 ш ба тариалсан талбай 9029м² тариалалт хийж үүнээс 44 тн ургац хураан авч, тариалсан талбай хэмжээ урьд онтой харьцуулахад 1179м²-аар нэмэгдэж, хураан авсан ургацын хэмжээ 10 тн-оор өссөн. /100/</p> <p>1.2.ХХААХҮЯамны ТЭДСангаас 6*20 хэмжээтэй хүлэмжний нийлэг хучлагыг 50% хөнгөлөлттэй үнээр /189 000 төгрөг/ 10 ногоочин худалдан авсан. /100/</p> <p>1.3.ХХААХҮЯамны ТЭДСангаас зээлээр олгосн 4х8 хэмжээтэй 4 ширхэг хүлэмжийг Цагаандэлгэр, Сайнцагаан, Дэрэн, Дэлгэрцогт сумдын ногоочдод олгосон. Үр дүнд шинээр 128 м² талбай, ургац 3,3 тн- оор нэмэгдэж байна. /100/</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p>1.4.Аймгийн ХХҮГ-ын Хүнсний ногоо тариалах, ажилгүй иргэдийг ажлын байраар хангах хөтөлбөрийн хүрээнд 10 иргэнийг 1 бүлэгт хуваан 5.0 сая төгрөгний үнэ бүхий төмсний үр 200 кг, хүлэмж 1 ширхэг, үр, үрсэлгээг, тоног төхөөрөмжийг нийлүүлж мэргэжил арга</p>			

		<p>зүйн зөвлөгөө өгч ажилласны үр дүнд төмс 0,1 талбайгаас 0,5 тн, хүнсний ногоо 60м² хүлэмжнээс 1,5 тн тус тус хураан авсан /100/.</p>
<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:</p>		<p>2-р Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл. 2.1. Сайнцагаан, Цагаандэлгэр, Гурвансайхан, Луус сумын СХСангаас 16 иргэнд нийт 109 сая төгрөгийн дэмжлэгийг /зуны хүлэмж, төмс, хүнсний ногоо тариалах үр, бордооны төхөөрөмж/ зээлийг гэрээ байгуулан олгоод байна. төслийн хүрээнд шинээр 10 ажлын байр нэмэгдсэн байна. /100/ 2.2. Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамжийн ажлыг АНАРЗОНЕ ХХК 2019 оны 12 дүгээр сарын 30-ны өдөр дотор хийж гүйцэтгэсэн байна. ОНХС-ийн 23,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар уг ажлыг хийж гүйцэтгэснээр хүнсний ногоо тасралтгүй тариалах боломж бүрдэж байна./100/</p>
<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:</p>		<p>3-р Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл. 3.1.ХХААХҮЯамнаас “Хүнсний ногоо” хөтөлбөр, хаврын тариалалтад зориулж өгсөн төмс, хүнсний ногооны 7 нэр төрлийн 534,5 кг үр буюу 1,5 сая төгрөгний үрийг хүлээн авч 15 сумдад хуваарилан тариаланчдад олгож үзүүлэн ажилласан. Үүний үр дүнд төмс 0,3 га-гаас 1,5 тн, хүнсний ногоо 1 га-гаас 15 тн-ийг ургацыг хураан авсан байна. /100/</p>   <p>Аймгийн хэмжээнд өргөст хэмх, лооль, чинжүү, амтат-гуа, тарвас зэрэг 20 000 ш үрсэлгээг ногоочид зах зээлд нийлүүлсэн байна. /100/</p>  
<p>4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:</p>		<p>4-р Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл. 4.1. ХХААХҮЯамнаас зохион байгуулсан Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний түүхт 60 жилийн ойн баярын арга хэмжээнд тариаланчдын төлөөлөл нийт 26 хүнийг оролцуулсан. Атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн хүрээнд төрийн одон медиалаар 39 тариаланч шагнагдсанаас Хөдөлмөрийн хүндэт медаль -1, Атарчдын алдар -28, Атарын 60 медаль-10, тариаланч шагнагдлаа. /100/</p>

		<p>Монгол ногоо хөтөлбөрөөс Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Хүлэмжинд хүнсний ногоо” ургуулах талаар сургалтанд 3 ногоочныг хамруулсан. /100/</p> <p>Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн зах зээлийн хөгжил хөтөлбөрийн хүрээнд эмэгтэйчүүд давамгайлсан 30 гаруй бүлгийгн 294 иргэнийг хамруулсан “Бизнес төлөвлөгөө, зээлийн төсөл боловсруулах, “Ногоо боловсруулах технологи”-ийн сургалтыг зохион байгуулж “Чадамжийн гэрчилгээ” олголоо./100/</p>  <p>Зах зээлийн бэлчээрийн удирдлага хөгжил төслөөс зохион байгуулсан БНХАУ-ын “Хүлэмжний аж ахуй туршлага судлах сургалтанд 2 хүн хамрагдсан./100/</p> <p>Өрхийн тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд, Сайнцагаан сумдтай хамтран нийт 30 газар тариалан эрхлэгчдэд талбай дээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гарын авлага зөвлөмжөөр 150 ш ханган ажилласан. /100/</p> 
<p>5-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн 1:</p>		<p>5-р Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл.</p> <p>5.1. Орхон болон Төв аймагт Сайнцагаан сумын 3 иргэн, Дэлгэрцогт сумын 1 иргэн төмс 4,5 га-гаас 72 тн, хүнсний ногоо-0,5 га-гаас 7тн-ийг хураан авсан байна. /100/</p>
<p>7.</p> <p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>		<p>Ололт: Аймгийн хэмжээнд хаврын тариалалт болон намрын ургац хураалтын үр дүнд төмс 21,4 га-аас 208 тн хүнсний ногоо 13,3 га-гаас 118 тн ургац хураан авсан нь хүн амын хэрэгцээт төмс, хүнсний ногооны 15 хувийг хангаж байна.</p> <p>Дутагдал: Цаашид бусад нэр төрлийн хүнсний ногооны талбайн хэмжээ нэр төрлийг нэмэгдүүлэх, тариалачдын хөнгөлөлттэй нөхцлөөр зээл дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.</p>

8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хөтөлбөрийг ХХААХҮЯамны ТЭДС, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, СХСангаас санхүүжүүлж байна.					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		100	100	100	100	100	100
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ					


Хөтөлбөрийн хэрэгжилт гаргасан: Газар тариалангийн үйлдвэрлэлийн технологи хариуцсан
мэргэжилтэн Э.Эрдэнэтунгалаг

“ЖИМС, ЖИМСГЭНЭ” ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

2019.12.05

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл																	
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилго: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын 02 өдрийн 25 тогтоолын батлагдсан.</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн чацарганын тариалалтыг болон бусад нэр төрлийн жимс, жимсгэнийн тариалалтыг тус бүр 40 га талбайд хүргэж, өрхийн болон аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлэхэд оршино.</p>																	
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв																	
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯамнаас</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААГазар</p>																	
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1:Говийн нөхцөлд жимс жимсгэнэ тариалах, хадгалах, боловсруулах, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тариалан эрхлэгчдийг сургах, дадлагажуулах</p> <p>Зорилт 2:Говийн бүсэд цаг уурын нөхцөлд тэсвэртэй, суулгац болон сортыг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран нутагшуулах, хангамжийг нэмэгдүүлэх;</p> <p>Зорилт3:Жимс, жимсгэнийн тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, салбарын хүний нөөцийг чадавхжуулах.</p>																	
5.	<table border="1" style="width:100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width:10%;"></td> <td style="width:20%;">Төсөв (нийт шаардагдах зардал)</td> <td colspan="3" style="text-align:center;">Орон нутгийн төсвөөр-2019 онд</td> </tr> <tr> <td></td> <td>Үүнд:</td> <td style="text-align:center;">Төсөв (он)</td> <td style="text-align:center;">Гүйцэтгэл</td> <td style="text-align:center;">Хувь</td> </tr> <tr> <td></td> <td>Багц 1</td> <td>2019 онд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс 50 сая/ төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.</td> <td>Энэ онд зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаанд 100 хувь хийгдэж дууслаа.</td> <td style="text-align:center;">100</td> </tr> </table>		Төсөв (нийт шаардагдах зардал)	Орон нутгийн төсвөөр-2019 онд				Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь		Багц 1	2019 онд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс 50 сая/ төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.	Энэ онд зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаанд 100 хувь хийгдэж дууслаа.	100			
	Төсөв (нийт шаардагдах зардал)	Орон нутгийн төсвөөр-2019 онд																	
	Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь															
	Багц 1	2019 онд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс 50 сая/ төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.	Энэ онд зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаанд 100 хувь хийгдэж дууслаа.	100															
.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.																	

	<p>1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:</p>	<p>1-р Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл. 1.1. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Жимс жимсгэнийг тариалалт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт” зөвлөгөөнд орон нутгын төлөөлөл 25 тариаланчдыг хамруулсан байна. /100/  </p> <p>1.2. Жимс жимсгэний тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд, Сайнцагаан сумдтай хамтран нийт 90 газар тариалан эрхлэгчдэд талбай дээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 100 ширхэг гарын авлага зөвлөмжөөр ханган ажилласан. /100/ </p>
	<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:</p>	<p>2-р Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл. 2.1. ХХААХҮЯ-аас ирүүлсэн “Жимсний суулгац зээлээр олгох” СШ/18/ЖЖСЗ-01 төсөл заралсаны дагуу аймгийн Ард телевиз, АСЦогцолбор, байгууллагын веб сайт, сумдад албан тоот хүргүүлэн суулгацын мэдээллийг тариаланчдад хүргүүлсэн. Үүний үр дүнд дээрх төсөлд 6 иргэнийг хамруулан хаврын тариалалтаар чацарганы 520 ш, бэсрэг алим 107 ш-ийг суулгацыг олгон, тариалалт хийсэн байна./100/ </p> <p>2019 онд шинээр жимс жимсгэнийг тариалалт 4,4 га-аар нэмэгдэж, ургац 8,7 тн хураан авсан. Урьд оноос тариалсан талбайг 1,2 га-гаар, хураан авсан ургац 6,4 тн-оор өссөн үзүүлэлттэй байна./100/ 2.2. 2019 онд шинээр жимс жимсгэнийг тариалалт 4,4 га-гаар нэмэгдэж, ургац 8,1 тн хураан авсан. Урьд оноос тариалсан талбайг 1,2 га-гаар, хураан авсан ургац 6,4 тн-оор өссөн үзүүлэлттэй байна. /100/</p>
	<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:</p>	<p>3-р Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл.</p>

		<p>3.3. Жимс жимсгэнийг зохистой хэрэглээг нэмэгдүүлэх, дадал болгох ач тусыг тариалан эрхлэгчдэд fb хаяг болон талбай дээр очиж мэргэжил зүйн зөвлөгөө өгч ажилласан. /100/</p> <p>3.4. НҮБ-ийн Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн зээлийн хөрөнгөөс санхүүжигдэх IFAD буюу “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн бизнесийн орчин сайжруулах Сайхан-Овоо сумын Чацаргана төгөл хоршооны чацаргана боловсруулах 50 сая төгрөгийн төслийг аваад байна. Төсөл хэрэгжүүлэгч Сайхан-Овоо сумын иргэн Чинбат төсөл бичих, бизнес төлөвлөгөө боловсруулах, компьютерийн мэдлэг олгох 14 хоногийн сургалт болон жимс, жимсгэний салбарын зөвлөгөөнд хамрагджээ./70/</p>			
					
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололт: 2019 онд шинээр жимс жимсгэний тариалалт 4,4 га-аар нэмэгдэж, ургац 8,7 тн хураан авсан. Урьд оноос тариалсан талбайг 1,2 га-гаар, хураан авсан ургац 6,4 тн-оор өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Дутагдал: Цаашид бусад нэр төрлийн жимс, жимсгэний талбайн хэмжээ нэр төрлийг нэмэгдүүлэх, бага оврын боловсруулах үйлдвэр бий болгох шаардлагатай байна.</p>			
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хөтөлбөрийг ХХААХҮЯамны ТЭДС, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс, СХСангаас санхүүжүүлж байна.			
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		90	100	100	70
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ			

Хөтөлбөрийн хэрэгжилт гаргасан: Газар тариалангийн үйлдвэрлэлийн технологи хариуцсан мэргэжилтэн Э.Эрдэнэтунгалаг